



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 1/52

Баян-Өндөр сум

Г Тусгай зөвшөөрөл сунгах, олгох, хаягийн  
шилжилт хийх тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3, 19.17, 19.18, 19.20, Зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1, 6 дугаар зүйлийн 2.1.1, 2.1.2, 2.1.4 дэх заалтууд, Аймгийн Засаг даргын 2022 оны А/764 дүгээр захирамж, ЭМС-ын 2021 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/400, 2023 оны 03-р сарын 24-ны "Журам шинэчлэн батлах тухай" А/100 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын дэргэдэх "Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс"-ын 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 04 дугаар хурлын шийдвэрийн дагуу хаягийн шилжилт хийх байгууллагуудыг нэгдүгээр, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох байгууллагуудыг хоёрдугаар, цуцлах байгууллагуудыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эрүүл мэндийн газарт сар бүрийн мэдээ тайланг хугацаанд нь ирүүлж, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, стандартуудыг хэрэгжүүлэн ажиллахыг эрүүл мэндийн байгууллагуудын захирал, дарга наарт үүрэг болгосугай.
3. Тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг комиссын гишүүд, ажлын албаны дарга, гишүүдэд даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөтийн хэлтсийн Бодлого төлөвлөлт хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн /Б.Уртнасан/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ



Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны

07. дүгээр сарын 06ны өдрийн

11 дугаар тушаалын 1 хавсралт

9043446 2020030036

## ХАЯГИЙН ШИЛЖИЛТ ХИЙХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИЛЭЛ

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хүчинтэй хугацаа
1	Шидэт номин ХХК-ын "Шидэт номин" 1-р зэрэглэлийн эмийн сан	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах	Согоот багийн 6-16-921 тоотоос Эрдэнэ багийн байранд шилжүүлж, 2-р зэрэглэл болгох	2026.12.01
2	Уян чагнуур ХХК-ын "Бүжинлхам"	Хүүхдийн клиник	Дээдэс 2-р байрнаас Чандмань баг 7-р хороолол 1-120/3-р байр 101 тоотод шилжүүлэх	2027.12.27
3	Бахайн Ам ХХК-ын "Цахирма фарм" 1-р зэрэглэлийн эмийн сан	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах	Согоот баг, 6-14-23 тоотоос Оюут баг 2-13 байрны 01 тоот руу шилжүүлэх	2025.03.11

Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны

17. дүгээр сарын 06.ны өдрийн

1/0 дугаар тушаалын 2 хавсралт

9043446 2020030036

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭР ОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН НЭР,  
ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг, байршил	Хугацаа
1	Мөнхийн Тун Мед ХХК-ын "Мөнхийн тун мед" 2-р зэрэглэлийн эмийн сан	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах	Чандмань баг 7-р хороолол 1-120/3-р байр 101 тоотод	5 жил
2	БҮРИДЭМ ХХК-ын "Мантра фарм" 2-р зэрэглэлийн эмийн сан	Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах	Оюут баг 2а хороолол, 10-3 байр, Y-5 тоот	5 жил

Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны  
... дүгээр сарын 06-ны өдрийн  
... дугаар тушаалын 3 хавсралт  
9043446 2020030036

ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦУЦЛАХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
1	Төр -уул ХХК-ын "Шидэт тун"	2-р зэрэглэлийн эмийн сан
2	Намуун фарм ХХК-ын "Намуун"	1-р зэрэглэлийн эмийн
3	Жаргалан ХХК-ын "Жаргалан"	1-зэрэглэлийн эмийн сан